



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 24 өдөр

Дугаар А/579

Есонбулаг

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалт, 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.16 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.5 дахь заалт, "Говь-Алтай 80+" эрүүл мэндийн хөтөлбөрийн 7.1.5 дахь заалт аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2024 оны 24 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.7 дахь хэсэг, Говь-Алтай 80+ эрүүл мэндийн хөтөлбөр хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Тонхил, Төгрөг, Бугат" сумдад 0-16 настай хүүхдийн урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоо, эмчилгээ, сургалт хийх ажлыг гэрээ байгуулан, гүйцэтгүүлэх эрхийг Эрүүл мэндийн газар (Г.Лхагважаргал)-т олгосугай.

2.Шаардагдах 18,334,000 (арван найман сая гурван зуун гучин дөрвөн мянга) төгрөгийг "Говь-Алтай 80+" эрүүл мэндийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд батлагдсан эх үүсвэрээс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (С.Мөнхжаргал) Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Ж.Амгаланбаатар)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ